



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийг балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгөд бүртгэлтэй, 13,248,000.00 (арван гурван сая хоёр зуун дөчин найман мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны Шүүхийн Тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэллхам, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Г.Болормаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,

АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл Д.НАРАНГЭРЭЛ

132001576

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
17 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
БАЯНЗҮРХ, СҮХБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Биет бус хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Газар эзэмших эрх, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2-р хороо	2017.05.29	м.кв	600	13,248,000.00
Нийт дүн					13,248,000.00 (арван гурван сая хоёр зуун дөчин найман мянган)